



МОНГОЛ УЛСЫН  
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА  
ХОЛБООНЫ ЯАМ

Сүхбаатарын талбай 1, Чингэлтэй дүүрэг,

Улаанбаатар хот, 15160

Утас: 33 07 81, Факс: (976-11) 33 07 80,

Цахим шуудан: info@mddc.gov.mn,

Цахим хуудас: www.mddc.gov.mn

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН  
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА

2023. 02. 28. № 02/418  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т


Тайлан хүргүүлэх тухай

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны “Ил тод байдлын шалгуур үзүүлэлт”-ийн 2022 оны жилийн эцсийн биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн үүгээр хүргүүлж байна.

Хавсралт 11 хуудастай.

ДЭД САЙД

Ж.ЭРХЭМБААТАР



1523081454

Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайдын  
2023 оны 02 дугаар сарын 27.-ны өдрийн  
02/02/2023 дугаар албан бичгийн 2.. дүгээр хавсралт

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ  
“ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ”-ИЙН ХЭРЭГЖИЛТЭД  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН**

2023 оны 02 сарын 27-ны өдөр

№

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Байгууллагын 2022 оны сүүлийн хагас жилийн байдлаар Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, гүйцэтгэлийг нь тогтоон үр дүнг үнэлэн, зөвлөмж, дүгнэлт гаргаж, удирдлагыг үнэн зөв бодит мэдээллээр ханган, ил тод байдлын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Хяналтад авсан хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.7-д заасны дагуу Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийн үнэлгээ хийх аргачлалыг удирдлага болгон үнэлсэн болно.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээ

Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан /new.unelgee.gov.mn/-д Цахим хөгжил, харилцаа холбооны яамны чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдалд хамаарах 10, хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдалд хамаарах 6, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдалд хамаарах 15, үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдалд хамаарах 2, бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдалд хамаарах 13 буюу нийт 46 үзүүлэлтийн хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт

Нийт 46 шалгуур үзүүлэлтийн дагуу гаргасан тайлангаар 100 хувь буюу 2022 онд багтааж ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан 31, хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 2, одоогоор тухайн төрлийн мэдээ байхгүй ч ирээдүйд

тайлагнах магадлалтай 5, тус яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахгүй 8 шалгуур үзүүлэлт байна.

Хэрэгжилтийн хугацаа тооцох болоогүй 2 шалгуур үзүүлэлтийг дурдвал:

1. “2.4. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам”-ыг ил тод байршуулах шалгуур үзүүлэлтийн хувьд “2023 оны 1 дүгээр улиралд багтаан баталж байршуулахаар байна” гэж тайлагнасан;

2. “3.3. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт”-ийг ил тод байршуулах шалгуур үзүүлэлтийн хувьд “Мэдээлэх хугацаа болоогүй” гэж тайлагнасан бөгөөд дээрх ил тод байршуулах шалгуур үзүүлэлтийн тухайд хуулийн хугацаандаа буюу 2023 оны 1 дүгээр улиралд багтаан мэдээлэл байрших бүрэн боломжтой байна.

Мөн цаг үеийн шинжтэй буюу одоогоор тухайн төрлийн мэдээлэл байхгүй ч ирээдүйд бий болсон тохиолдолд тайлагнах боломжтой ил тод байршуулах шалгуур үзүүлэлтийг дор дурдвал:

1. “1.4. Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан”-г ил тод байршуулах шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн хувьд тус яамнаас хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан одоогоор хийгээгүй тул тайлан гарсан тохиолдолд яамны цахим хуудасны “ил тод байдал” цэсийн “үйл ажиллагааны ил тод байдал” дэд цэсийн үйл ажиллагааны тайлан хэсэгт тухай бүр оруулах боломжтой болно” гэж тайлагнасан;

2. “3.12. Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл”-г ил тод байршуулах хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтийн хувьд “Одоогоор мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагаас хүсэлт гаргаагүй тул энэ талаарх мэдээлэл байхгүй байна” гэж тайлагнасан;

3. “5.2. Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт”-ыг ил тод байршуулах шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн хувьд “Тус яаманд хамаарах оюуны өмч байхгүй болно” гэж тайлагнасан;

4. “5.4. Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл”-ийг ил тод байршуулах шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн хувьд “Тус яамны эзэмшилд газар байхгүй тул мэдээлэл оруулах боломжгүй байна” гэж тайлагнасан;

5. “5.12. Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт”-ийг ил тод байршуулах хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтийн хувьд “Цахим хөгжил, харилцаа холбооны яамны зардлаар суралцаж байгаа суралцагч байхгүй байна” гэж тус тус тайлагнажээ.

Бусад 8 шалгуур үзүүлэлтийн хувьд тус яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахгүй буюу цаашид ил тод тайлагнах боломжгүй байх тул хасуулах шаардлагатай байна. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хувьд цөөн мэдээллүүдийг хугацаа хоцроосон төлөвтэй боловч ил тодоор байршуулсан тул хэрэгжилт хангалттай гэж үзсэн болно.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ яамны цахим хуудас /mddc.gov.mn/-ны мэдээлэл, мэдээллийн самбар, бусад мэдээллийн хэрэгсэл

ашиглан нийтэлж байгаа эсэх, мэдээллийг ил тод үнэн зөвөөр мэдүүлсэн эсэхэд хяналт тавьж, хэрэгжилтийн тайланг жил бүрийн 3 дугаар сарын 1-ний өдөрт багтаан тайлагнаж байна.

Цахим хөгжил, харилцаа холбооны яам нь 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс үйл ажиллагаа явуулж эхэлсэн ба шинэчлэн батлагдсан хууль тогтоомж, холбогдох журмын дагуу цахим хуудастаа ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг бүрэн дүүрэн шинэчлэн оруулсан эсэхийг нягтлан, дараах зүйлсийг харгалzan үзэж хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн болно. Үүнд:

1. Яамны цахим хуудас болоод мэдээллийн цахим самбарт шалгуур үзүүлэлтүүдийг тухай бүр ойлгомжтой байдлаар байршуулж, байгаа эсэх

2. Хуулийн хугацаатай /шилэн данс г.м/ ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг өдөр тутамдаа хэрэгжүүлж байгаа эсэх

#### Тав. Зөвлөмж

Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг үнэлэхэд дараах зөвлөмжийг Төрийн захиргааны удирдлагын газарт өгч байна.

1. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журмын хавсралтын дагуу жил бүрийн 02 дугаар сарын 20-ны өдөрт багтаан ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хангасан хэрэгжилтийн тайланг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хамаарах баримтын хамт хүлээлгэн өгч хэвшсэн байх.


2. Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн мэдээллийг байгууллагын цахим хуудаст иргэдэд ойлгомжтой байдлаар бэлтгэн байршуулж байх.

3. Мэдээллийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу нотлох баримттайгаар тайлагнаж хэвших.

Нээлттэй мэдээллийг цахим хуудас, мэдээллийн самбар, бусад мэдээллийн хэрэгсэл ашиглан нийтэлсэн бол шалгуур үзүүлэлт тус бүрийг хангалттай оноогоор дүгнэх боломжтой гэдгийг онцлох нь зүйтэй байна.

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР**

Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайдын  
2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн  
04/02/2023 дугаар албан бичгийн 2 дугаар хавсралт



Цахим хөгжил, харилцаа холбооны яамны  
“Ил тод байдлын шалгуур үзүүлэлт”-ийн  
2022 оны сүүлийн хагас жилийн тайлан

2022.02.16

Улаанбаатар хот

Д/д	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг цахим хуудаст оруулсан байдал	Хэрэгжилтийн хувь
Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал.			
1	1.1. Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт болон Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг “Алсын хараа – 2050”, Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх замаар эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн нэг болгох зорилт тавьж, “Цахим Үндэстэн” болохuriалгыг дэвшүүлсэн. Энэхүү ажлын хүрээнд дижитал дэд бүтэц, цахим засаглал, мэдээллийн аюулгүй байдал, тоон бичиг үсгийн чадавх, инновац үйлдвэрлэл, үндэсний хөгжлийн хурдасгуур гэсэн стратегийн зургаан том төлөвлөгөөг баталсан бөгөөд яамны цахим хуудасны “яамны тухай” цэсийн “стратегийн зорилго” цэсэд байршуулсан болно.	100%
2	1.2. Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг;	Цахим хуудасны “яамны тухай” цэсийн, “бүтэц зохион байгуулалт” дэд цэсэд байршуулсан.	100%
3	1.3. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит,	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт батлах тухай” 55 дугаар тогтоолд өөрчлөлт оруулсны дараагаар уг тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит,	100%

	санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;	санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмжийг оруулахаар байна. Мөн мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, албан шаардлага, зөвлөмжийг “ил тод байдал” цэсийн “үйл ажиллагааны ил тод байдал” дэд цэсийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан хэсэгт байршуулсан байна.	
4	1.4. Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан;	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан одоогоор байхгүй бөгөөд тайлан гарсны дараагаар яамны цахим хуудасны “ил тод байдал” цэсийн “үйл ажиллагааны ил тод байдал” дэд цэсийн үйл ажиллагааны тайлан хэсэгт тухай бүр оруулах боломжтой болно.	-
5	1.5. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан;	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайланг яамны цахим хуудасны “ил тод байдал” цэсийн “үйл ажиллагааны ил тод байдал” дэд цэсийн үйл ажиллагааны тайлан хэсэгт тухай бүр оруулж байна.	100%
6	1.6. Үйл ажиллагаандаа мөрдеж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;	Цахим хуудасны яамны тухай цэсийн, Хууль эрх зүй дэд цэсэд байршуулсан “Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт” хэсэгт байршсан.	100%
7	1.7. Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг;	Цахим хуудасны Ил тод байдал цэсийн Хүний нөөцийн ил тод байдал дэд цэсэд хүний нөөцийн удирдлага хэсэгт байршсан.	100%
8	1.8. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;	Цахим хуудасны “Ил тод байдал” цэсийн “Үйл ажиллагааны ил тод байдал” цэсэд “Өргөдөл гомдол шийдвэрлэлт” байршсан.	100%
9	1.9. Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл;	Цахим хуудасны “мэдээ” цэсийн “статистик” хэсэгт салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл байршсан.	100%
10	1.10. Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр;	Цахим хуудасны “мэдээ” цэсэд тухай бүр байршиж байна.	100%

Хоёр. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал

11	2.1. Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;	Цахим хуудаст “Ил тод байдал” цэсийн “Хүний нөөцийн ил тод байдал” дэд цэсэд Төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалтын мэдээ материалыг тухай бүр оруулан ажиллаж байна.	100%
12	2.2. Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам;	Цахим хуудаст “Ил тод байдал” цэсийн “Хүний нөөцийн ил тод байдал” дэд цэсэд Төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулах журам байршсан.	100%
13	2.3. Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм;	Цахим хуудаст “Ил тод байдал” цэсийн “Хүний нөөцийн ил тод байдал” дэд цэсэд “Ёс зүйн зэвлөл” хэсэгт дүрэм, журам байршсан.	100%
14	2.4. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам;	2023 оны 1 дүгээр улиралд багтаан баталж байршуулахаар байна.	-
15	2.5. Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;	Цахим хуудаст “Ил тод байдал” цэсийн “Хүний нөөцийн ил тод байдал” дэд цэсэд “Хүний нөөцийн удирдлага” хэсэгт байршсан.	100%
16	2.6. Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.	Цахим хуудаст “Ил тод байдал” цэсийн “Хүний нөөцийн ил тод байдал” дэд цэсэд “Хүний нөөцийн удирдлага” хэсэгт байршсан.	100%
Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
17	3.1. Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл;	Цахим хуудасны “Шилэн данс” цэсэд “Шилэн дансны цахим систем”-ийг холбож тухай бүр мэдээллийг тайлагнан ажиллаж байна. Шилэн дансанд нийт 2 мэдээлэл байршуулахаас 2 мэдээллийг хугацаанд нь оруулсан.	100%
18	3.2. Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан;	Цахим хуудасны “Шилэн данс” цэсэд “Шилэн дансны цахим систем”-ийг холбож тухай бүр мэдээллийг тайлагнан ажиллаж байна. Шилэн дансанд нийт 20 мэдээлэл байршуулахаас 16 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн, 1 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй байна.	100%
19	3.3. Санхүүгийн тайланда хийсэн аудитын дүгнэлт;	Цахим хуудасны “Шилэн данс” цэсэд “Шилэн дансны цахим систем”-ийг холбож тухай бүр мэдээллийг тайлагнан ажиллаж байна. Мэдээлэх хугацаа болоогүй.	-
20	3.4. Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;	Цахим хуудасны “Шилэн данс” цэсэд “Шилэн дансны цахим систем”-ийг холбож тухай бүр мэдээллийг тайлагнан ажиллаж байна. Шилэн дансанд нийт 12 мэдээлэл байршуулахаас 10 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн.	100%
21	3.5. Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар;	Цахим хуудасны “Шилэн данс” цэсэд “Шилэн дансны цахим систем”-ийг холбож тухай бүр мэдээллийг тайлагнан ажиллаж байна. Шилэн	100%

		дансанд нийт 18 мэдээлэл байршуулахаас 16 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн.	
22	3.6. Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;	Цахим хуудасны "Шилэн данс" цэсэд "Шилэн дансны цахим систем"-ийг холбож тухай бүр мэдээллийг тайлагнан ажиллаж байна. Шилэн дансанд нийт 12 мэдээлэл байршуулахаас 11 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн.	100%
23	3.7. Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт;	Цахим хуудасны "Шилэн данс" цэсэд "Шилэн дансны цахим систем"-ийг холбож тухай бүр мэдээллийг тайлагнан ажиллаж байна. Шилэн дансанд нийт 12 мэдээлэл байршуулахаас 11 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн.	100%
24	3.8. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;	Цахим хуудасны "Шилэн данс" цэсэд "Шилэн дансны цахим систем"-ийг холбож тухай бүр мэдээллийг тайлагнан ажиллаж байна. Шилэн дансанд нийт 12 мэдээлэл байршуулахаас 11 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн.	100%
25	3.9. Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл;	Цахим хуудасны "Шилэн данс" цэсэд "Шилэн дансны цахим систем"-ийг холбож тухай бүр мэдээллийг тайлагнан ажиллаж байна. Шилэн дансанд нийт 1 мэдээлэл байршуулахаас 1 мэдээллийг хугацаанд нь байршуулсан.	100%
26	3.10. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;	Цахим хуудасны "Шилэн данс" цэсэд "Шилэн дансны цахим систем"-ийг холбож тухай бүр мэдээллийг тайлагнан ажиллаж байна. Шилэн дансанд нийт 12 мэдээлэл байршуулахаас 11 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн.	100%

27	3.11. Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт;	Цахим хуудасны "Шилэн данс" цэсэд "Шилэн дансны цахим систем"-ийг холбож тухай бүр мэдээллийг тайлагнан ажиллаж байна. Шилэн дансанд нийт 12 мэдээлэл байршуулахаас 11 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн.	100%
28	3.12. Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл;	Одоогоор мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан мэдээлэл байхгүй байна.	-
29	3.13. Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн;	Тус яаманд хамаарах төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр байхгүй тул холбогдох мэдээлэл одоогоор байхгүй ба Шилэн дансанд нийт 13 мэдээлэл байршуулахаас 10 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн.	100%
30	3.14. Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажлыг яамны цахим хуудасны "Ил тод байдал" цэсэд "Судалгаа" дэд цэсийг байршуулсан.	Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажлыг яамны цахим хуудасны "Ил тод байдал" цэсэд "Судалгаа" дэд цэсийг байршуулсан.	100%
31	3.15. Хууль тогтоомжид заасан бусад.	Яамны цахим хуудаст "11-11 төв" цэс болон "e-mongolia" цэсийг нэмж байршуулсан болно.	100%
Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
32	4.1. Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл;	Цахим хөгжил, харилцаа холбооны яам нь төрийн захиргааны төв байгууллага бөгөөд гадагш чиглэсэн үйлчилгээ үзүүлдэггүй. Иймд аливаа бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл байхгүй. Харин тус яамнаас тоон гарын үсгийн тусгай зөвшөөрлийг олгодог тул "ил тод байдал" цэсийн "тусгай зөвшөөрөл" дэд цэсэд тусгай зөвшөөрөл хүсэгчийн бүрдүүлэх баримт бичгийн мэдээллийг байршуулсан.	100%

33	4.2. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.	Тус яам нь хуулийн хүрээнд тоон гарын үсгийн тусгай зөвшөөрөл олгодог. Яамны цахим хуудасны "Ил тод байдал" цэсийн "үйл ажиллагааны ил тод байдал" дэд цэсэд тусгай зөвшөөрөл олгоход шаардагдах баримт бичгийн мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаягийг байршсан. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журмыг яамны цахим хуудасны хууль, эрх зүй цэсийн "Бодлогын баримт бичиг" дэд цэсэд байршуулсан.	100%
Тав. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
34	5.1. Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал;	Яамны цахим хуудасны "хууль, эрх зүй" цэсийн "хууль эрх зүйн санал баримт бичигт санал авах" дэд цэсэд байршуулсан.	100%
35	5.2. Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт;	Тус яаманд хамаарах оюуны өмч байхгүй болно.	-
36	5.3. Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл;	Тус яаманд хамаарах "хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл" байхгүй тул цахим хуудаст оруулах мэдээлэл байхгүй.	-
37	5.4. Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл;	Тус яамны эзэмшилд газар байхгүй тул мэдээлэл оруулах боломжгүй байна.	-
38	5.5. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг;	Цахим хөгжил, харилцаа холбооны яам нь төсвийн байгууллага учраас оруулах мэдээлэл байхгүй.	-

39	<p>5.6. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл;</p>	<p>Цахим хөгжил, харилцаа холбооны яам нь төсвийн байгууллага учраас оруулах мэдээлэл байхгүй.</p>	
40	<p>5.7. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл;</p>	<p>Цахим хөгжил, харилцаа холбооны яам нь төсвийн байгууллага учраас оруулах мэдээлэл байхгүй.</p>	
41	<p>5.8. Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл;</p>	<p>Цахим хөгжил, харилцаа холбооны яам нь төрийн захиргааны төв байгууллага тул үйлдвэрлэл үйлчилгээ явуулдаггүй болно.</p>	
42	<p>5.9. Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт зэрэг мэдээлэл байхгүй;</p>	<p>Тус яаманд хамаарах барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт зэрэг мэдээлэл байхгүй.</p>	
43	<p>5.10. Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль</p>	<p>Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хамаарахгүй тул мэдээлэл байхгүй.</p>	

	орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ;		
44	5.11. Нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл;	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны цахим хуудасны "Ил тод байдал" цэсийн "Нээлттэй өгөгдөл" дэд цэсэд байршсан.	100%
45	5.12. Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт;	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны зардлаар суралцаж байгаа суралцагч байхгүй байна.	-
46	5.13. Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл.	Одоогоор оруулах бусад мэдээлэл байхгүй.	-
Биелэлтийн дундаж хувь			100%